

Inner Mongolia Yili Industrial Group Co.

/600887.SSE/

Компанийн тухай

Inner Mongolia Yili Industrial Group Company Limited нь 1930 онд үүссэн Өвөр Монголын Хөх хотод төвтэй Хятадын сүү болон сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани юм. Үүнд шингэн сүү, зайрмаг, хуурай сүү, тараг болон бяслаг багтдаг байна.

Хятад 2022 онд 40 сая тонн сүү үйлдвэрлэсэн бөгөөд энэ нь дотоодын нийт хэрэгцээний 75%-ийг хангажээ. Харин Yili Group нь нийт сүүний үйлдвэрлэлийн 15% болох 6 сая тонн сүү үйлдвэрлэсэн байна. Хятад дотоодын хэрэгцээний үлдсэн 25%-ийг Шинэ Зеланд, Герман, Франц, Австралиас гадна өөр 16 улсаас импортлодог байна. Хэдийгээр Хятад сүүн үйлдвэрлэлээрээ дэлхийд дөрөвт багтдаг ч нэг хүнд ноогдох хэмжээ нь дэлхийн дунджаас 3 дахин бага байна.

Хятадын уламжлалт хоол хүнсэнд сүү ховор хэрэглэгддэг болон бусад улсуудтай харьцуулахад үйлдвэрлэлийн зардал өндөр байдаг нь тухайн зах зээлийн өсөлтийг удаашруулж байна. Хятадын татварын дараах орлогын өсөлт болон глобалчлалын нөлөөгөөр амьдралын хэв маягт өөрчлөлт орж сүүн хэрэглээ илүү өсөх төлөвтэй байна.

Yili компани нь Ковидын үеэр ашигтай ажиллаж чадсан бөгөөд хувьцааны ханш 2 дахин өсжээ. Улмаар дэлхийн топ 5 брэнд үнэлгээний байгууллага болох Brand Finance-ийн "2020 оны Хүнс болон Ундааны тайлан"-д хамгийн үнэ цэнтэй брэндээр шалгарчээ.

2023 оны 4-р сарын 1-ээс 2023 оны 5-р сарын 26-ны хооронд тус компани нь өөрсдийн 9,871,604 ширхэг хувьцааг буюу нийт хувьцааны 0.15 хувийг 297.18 сая юаниар буцаан худалдан авчээ. Улмаар 2022 оны 12-р сарын 20-нд зарласан хувьцаа халааслах хөтөлбөрийн хүрээнд тус компани нийт эзэмшлийн 0.51%-ийг 1 тэрбум юанийн үнэлгээ бүхий 32,468,413 ширхэг хувьцааг халаасласан байна.

2008 онд The Sanlu Group-н үйлдвэрлэсэн сүүн нунтаг 300,000 нярай хүүхдийг хордуулж, 16 хүүхэд бөөрний чулуужилт үүсэж, 6 хүүхэд нас барсан байна. Үүнээс хойш Хятад хоол хүнсний хяналтаа сайжруулж эрүүл хоол хүнсэнд анхаарал ихээр тавьдаг болжээ. Тус үйл явдлаас шалтгаалж тус компани нь эрүүл хоол хүнс, нийлүүлэлтэнд илүү ач холбогдол өгч судалгаа хөгжлийн албанд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхэлсэн. Улмаар 2023 оны 6 сарын 26-нд Английн Лондон хотноо болсон Олон Улсын Сүүн Бүтээгдэхүүний Их Хуралд "Хүүхдийн сүүн бүтээгдэхүүн болон савлагаа" нэрэмжит шагналын ялагч болон өөр 17 шагнал авчээ.

Зорилтод ханш

36.17 CNY

Хувьцааны ханш

26.03 CNY

Зах зээл дээр

Зах зээлийн үнэлгээ (юаниар)	166.4 тэрбум
Дундаж арилжааны идэвх	14.57 сая ш
Хувьцааны тоо ширхэг	6.37 тэрбум ш
Нээлттэй арилжаалагдаж буй	5.35 тэрбум ш

52 долоо хоногийн ханш



Харьцаа, үзүүлэлтүүд

Жил	2021	2022	2023 (ТТМ)
Нэгж хувьцаанд ногдох ашиг	1.43	1.48	1.48
Үнэ-орлогын харьцаа (P/S)	2.25	1.55	1.32
Үнэ-ашигын харьцаа (P/E)	28.61	20.30	17.24
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	5.44	4.71	3.35
Ногдол ашгийн өгөөж	2.11%	3.21%	4.00%
Хөрөнгийн өгөөж (ROA)	8.54%	7.20%	4.42%
Өмчийн өгөөж (ROE)	18.25%	18.76%	18.20%

Бусад харьцаа үзүүлэлтүүд

Стандарт хазайлт (5 жил)	32.00%
Beta (5 жил)	1.04
Дундаж өгөөж (5 жил)	7.92%
Altman Z оноо	3.03
Ногдол ашгийн өгөөж	4.00%

Холбоо барих

Голомт Капитал ҮЦК

Судалгаа бэлтгэсэн: Хөрөнгө удирдлага.

Судалгааны газар

Хаяг: Парк Плэйс оффис, 4 давхар, 403 тоот,

Чингисийн өргөн чөлөө-24

Утас: (+976) 7012-1530

Цахим хаяг: <http://golomtcapital.com/>Email: info@golomtcapital.com

Гадаад арилжааны брокер:

(+976) 8610-3636

(+976) 8006-9977

Орлогын тайлан (сая юаниар)

Жил	2021	2022	Хэвтээ шинжилгээ 2021-2022	Босоо шинжилгээ 2022
Борлуулалтын орлого	110,595	123,171	11.37%	100.00%
Нийт зардал	76,417	83,119	8.77%	67.48%
Нийт ашиг	34,178	40,052	17.19%	32.52%
Хүү болон татварын өмнөх орлого	10,922	12,033	10.17%	9.77%
Татварын өмнөх орлого	8,150	10,112	24.08%	8.21%
Татвар	1051	1380	31.35%	1.12%
Цэвэр ашиг	7,078	8,705	22.98%	7.07%

Баланс (сая юаниар)

Эргэлтийн хөрөнгө	50,155	61,463	18.40%	46.93%
Эргэлтийн бус хөрөнгө	51,807	69,502	25.46%	53.07%
Нийт хөрөнгө	101,962	130,965	22.15%	100.00%
Эргэлтийн өр төлбөр	43,296	62,170	30.36%	47.47%
Эргэлтийн бус өр төлбөр	9,875	14,653	32.61%	11.19%
Нийт өр төлбөр	53,171	76,822	30.79%	58.66%
Нийт эздийн өмч	47,708	50,268	5.09%	38.38%

Мөнгөн гүйлгээ (сая юаниар)

Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	15,528	13,420	-13.57%	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ	(7,797)	(19,514)	150.27%	-
Санхүүжилтийн мөнгөн гүйлгээ	11,945	8,781	-26.49%	-
Нийт өөрчлөлт	19,676	2,688	-86.34%	-
Цэвэр мөнгөн гүйлгээ	8,845	6,774	-23.41%	-

Жил 2020 2021 2022 2023 ТТМ


Харьцаа үзүүлэлтүүд

Эргэлтийн харьцаа	0.82	1.16	0.99	0.96
Нийт эздийн өмчийн өгөөж	23.30%	18.25%	18.76%	18.20%
Нийт хөрөнгийн өгөөж	9.95%	8.54%	7.20%	4.42%
Хөрөнгийн эргэц	1.28	1.07	0.96	0.92

Нийт ахиуц ашиг	36.21%	30.90%	32.52%	31.96%
Цэвэр ахиуц ашиг	7.31%	7.87%	7.66%	7.69%
Санхүүгийн хөшүүрэг	2.33	2.22	2.38	2.60


Өрийн харьцаа	0.56	0.51	0.58	0.61
Үнэ-орлогын харьцаа (P/S)	2.54	2.25	1.55	1.32
Үнэ-ашгийн харьцаа (P/E)	34.80	28.61	20.30	17.24
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	8.65	5.44	4.71	3.35
Нэгж хувьцаанд ногдох ашиг	1.17	1.43	1.48	1.48

Inner Mongolia Yili Industrial Group компанийн хувьцааны ханшийн өсөлтийн хувийг SSE Composite индекстэй харьцуулснаар




Салбарын харьцуулалт

Салбарын Тор-5 компанитай харьцуулснаар




Түүхэн үнэлгээ



Нэгж хувьцаанд ногдох ашгийн өсөлт

NSRGY, SAP.TO ,D01.SI, KHC, BN.PA харьцуулснаар



ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТ

Хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт

Худалдан авсан		Зарсан	
Хөрөнгө оруулагч	Сая ширхэг	Хөрөнгө оруулагч	Сая ширхэг
Huatai-PineBridge Fund Management Co. Ltd.	+14.2	Fullgoal Fund Management Co. Ltd.	-24.01
Norges Bank Investment Management	+9.13	INVESCO Great Wall Fund Management	-7.06
China Asset Management Co. Ltd.	+8.76	ICBC Credit Suisse Asset Management Co. Ltd.	-4.28
Tianhong Asset Management Co. Ltd	+4.02	Congest S.A.	-1.87
MFS Investment Management	+2.99	China Southern Asset Management Co. Ltd.	-0.93
China Universal Asset Management Co. Ltd	+2.52	J.P. Morgan Asset Management Limited	-0.56
E Fund Management Co. Ltd.	+1.55	-	-
JPMorgan Asset Management Co. Ltd.	+0.3	-	-
T. Rowe Price Associates, Inc.	+0.01	-	-

Refinitiv

Шинжээчдийн таамаглал


Олон улсын хөрөнгө оруулалтын сангуудын ханшийн таамаглал

Ханшийн зорилт гаргасан	Зорилтот ханш	Одоогийн ханшаас %	Зөвлөмж	Огноо
ABCI Securities	31.20	19.86%	Худалдан авах	09/05/2023
Bocom International Sec	33.20	27.55%	Худалдан авах	08/29/2023
UOB Kay Hian PTE LTD	37.50	44.06%	Худалдан авах	08/09/2023
Pingan Securities Co. Ltd	-	-	Худалдан авах	04/28/2023
Soochow Securities	-	-	Худалдан авах	09/01/2022
SPDB International Securities	35.40	35.99%	Худалдан авах	08/01/2022
China Merchant Securities	36.00	38.30%	Худалдан авах	04/29/2022
CSC Securities	35.00	34.46%	Худалдан авах	04/28/2022
CMB International Global	44.00	69.03%	Худалдан авах	01/25/2022
Citic Securities	40.00	53.66%	Худалдан авах	12/31/2021
China Renaissance	37.70	44.83%	Худалдан авах	08/31/2021
Huatai Securities	40.02	53.74%	Худалдан авах	08/31/2021
Credit Suisse - Non-Japan Asia	40.00	53.66%	Худалдан авах	12/01/2020
HSBC	41.00	57.51%	Худалдан авах	11/23/2020
Дундаж	37.08	42.45%		
Мэдиан	36.29	39.41%		

Refinitiv

ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

Golomt_Capital published on TradingView.com, Sep 21, 2023 15:35 UTC+8



Golomt_Capital published on TradingView.com, Sep 21, 2023 15:33 UTC+8



2018 онд үүссэн ёроолын цэгийн (HL) дэмжлэгийн бүс дээр ирсэн нь ашиг алдагдлын харьцаа өндөр худалдан авалт хийх боломжтой байна. Богино хугацаандаа бага зэрэг унаж 25.12 хүрэх боломжтой ч өмнөх ёроолын цэгтэй ойрхон байгаа нь худалдаж авахад тохиромжтойг илтгэж байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээч болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно